



АЛТАНБУЛАГ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-07-30 № СА-2020/04-НА-02
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Алтанбулаг сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Алтанбулаг сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


Дүгнэлт

Алтанбулаг сумын Монгол Ардын намын хорооны Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Алтанбулаг сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...9..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Алтанбулаг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



АЛТАНБУЛАГ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР

**АЛТАНБУЛАГ СУМЫН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**



2020.07.27

сум

**АЛТАНБУЛАГ СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ
“ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”**

Ардын хувьсгалын өлгий Алтанбулаг сумын нийгэм эдийн засгийн хөгжлийг удирдаж ирсэн түүхэн уламжлал, туршлагыг тулгуурлан Монгол улсын хөгжлийн алсын хараа, чиг хандлагыг иш үндэс болгож, Монгол Ардын Намаас УИХ-ын 2020 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаа зохион байгуулж хэрэгжүүлснээр сумын хөгжлийн шинэ шатанд гаргах шаардлагын үүднээс сумын иргэд, ААН, ТББ-уудаас ирүүлсэн саналуудыг нэгтгэн дүгнэж, 2020-2024 онд Алтанбулаг сумын хөгжил дэвшил, сайн сайхны төлөө хийж хэрэгжүүлэх гол ажил, арга хэмжээг хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын МАН-ын Хороо сонгогчид Та бүхэндээ өргөн барьж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОЛОВСРОЛ, СОЁЛ

✦ **Боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, Алтанбулаг сумын хөгжлийн суурь үндэс гэж үзнэ.**

1.1 Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 100 жилийн ойг угтаж стандарт шаардлагад нийцсэн орчин үеийн цогц биеийн тамирын талбайтай болгоно.

1.2 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, 1-2 насны хүүхдийг хамруулах (ясли) боломжийг бүрдүүлнэ.

1.3 Сумын хэмжээнд байгаа сурагчид, сургуулийн насны хүүхдүүдийн тодорхой хувийг “Хөдөлмөр зуслан”-нд амрааж, амралтаараа сурч, өсөж хөгжих нөхцөлийг бий болгоно.

1.4 Малчин өрхийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсролыг олгох явуулын гэр цэцэрлэг ажиллуулах, эцэг эхчүүдийн боловсролыг дээшлүүлэх замаар тэдний оролцоонд түшиглэсэн хүүхдийн хөгжлийг дэмжинэ.

1.5 Цэцэрлэгийн багшийн ажлын ур чадварыг нэмэгдүүлж, сургалтын үйл ажиллагааг сайжруулж, хүүхдийг ажиглан судалгаа хийх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.6 **"НОМЫН САЙН НӨХӨР"** болон **"Д.НАЦАГДОРЖ-ТЭМДЭГТЭН"** болзолт уралдааныг жил бүр зохион байгуулж, их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрөөр үр дүнг дүгнэж, анги хамт олон хүүхэд багачуудыг урамшуулна.

1.7 Сумын болон сургуулийн номын сангийн нөөцийг үндэсний, дэлхийн сонгодог уран зохиолын номуудаар баяжуулж, цахим номын сантай болгоно.

1.8 Ахлах ангийн сурагчдад **"Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ?"** сургалтыг жил бүрийн 11-р сард тогтмол зохион байгуулна.

1.9 Хүүхдийг багаас нь сумынхаа түүх, соёл, уламжлалыг мэддэг, хөдөлмөрт дуртай, нутаг орноороо бахархах үзэл хүмүүжилтэй, байгалийн үзэсгэлэнт газруудыг танилцуулж эх оронч үзэл суулгаж, амьдралын зөв дадал хэвшилтэй, боловсролтой иргэн болгон төлөвшүүлэх бодлого баримтална.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНД, БИЕЙН ТАМИР СПОРТ, УРЛАГ СОЁЛ

✦ **Иргэн, гэр бүл, ажил олгогчдын оролцоонд тулгуурлан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэн төлөвшүүлж, эрүүл амьдралын хэв маягийг дэмжинэ.**

2.1 "Эрүүл хүүхэд-Эх орны ирээдүй" уриан дор хүүхэд бүрийг жил болгон эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, эрүүл өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2 Гүн нуурт Спорт зуслан шинээр бий болгож, үндэсний бөх, чөлөөт самбо, жудо бөхийн төрөл болон бусад спортын төрлөөр хичээллэх боломжийг бүрдүүлж ажиллуулна.

2.3 Жил бүр ахмад настан болон тусгай хэрэгцээт иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, амралт сувилалд амраах ажлыг зохион байгуулна.

2.4 Сумын ахмадын холбоог түшиглэж чөлөөт цагийн клуб байгуулж ахмадуудыг бие эрүүл, сэтгэл амар, ая тухтай амьдрах орчин бүрдүүлнэ.

2.5 Өсвөр үе, залуучууд, иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдраа хөгжүүлэн эрүүлжих Фитнес төвийг сумын спорт цогцолборыг түшиглэж байгуулна.

2.6 Иргэн бүрийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлнэ.

2.7 “Идэвхтэй эрүүл амьдрал” хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлнэ.

2.8 Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулж, “Архи тамхигүй” байгууллага хамт олныг шалгаруулж, бүх нийтийн үйлс болгон зохион байгуулна.

2.9 Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг бүрдүүлэхийн тулд сумын хэмжээнд бүх нийтийг хамарсан нийтийн спорт, спартакиадыг жил тутамд зохион байгуулж, нийтийн биеийн тамирын талбайд дасгал хөдөлгөөнийг өдөр бүр хэвшил болгоно.

2.10 “Авьяаслаг Алтанбулагчууд” хөтөлбөрийг боловсруулж, сумандаа урлаг соёлын үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэн дэмжиж ажиллана.

2.11 Сумын эрүүл мэндийн төвд шаардлагатай стандартад нийцсэн орчин үеийн үзүүлэлт сайтай тоног төхөөрөмж, дэвшилтэд технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.



2.12 Сумын спорт цогцолборт түшиглэж биеийн тамирын арга зүйч ажиллуулна.

2.13 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг (ангина) өвчнийг эрт илрүүлэх эмлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.14 “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.15 Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан, улирал тутамд явуулын баг ажиллуулж, малчин өрх бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

2.16 Сумын хэмжээнд хүн мал амьтны гоц халдварт өвчин дэлгэрэхээс сэргийлэх дэг журмыг мөрдөж, үүсэх бэрхшээл, сөрөг үр дагаврыг арилгах



ажил, амьдралын дотоод гадаад зохистой нөхцөлийг сэргээхэд урт, богино хугацааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг тусгайлан гаргаж мөрдөнө.

ГУРАВ. ГЭР БҮЛ

✚ Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.

3.1 Хувиараа болон гэр бүлээрээ ажил хөдөлмөр эрхлэх, шинэ ажлын байр бий болгох санал санаачилга гаргасан аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжиж, хамтран ажиллана.

3.2 Өрхийн орлого болон бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Залуусын боломж” хөтөлбөрт сумын залуу гэр бүлүүдийг хамруулна.

3.3 Ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүст хувиараа хөдөлмөрлөх, аж ахуй эрхлэх боломжийг олгож, гэр бүлийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэн, хаврын тариалалт, ургац хураалт, хадлан бэлтгэл зэрэг онцлогтой ажлын үед чөлөө олгох, зайнаас ажиллахыг дэмжинэ.

3.4 Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээн хөгжүүлнэ.

3.5 Их дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгссөн залуучуудыг орон нутагтаа ирж ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.


ДӨРӨВ. ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН

✚ Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай таатай орчин бүрдүүлж, хот суурин газар, хөдөө орон нутгийн амьдралын чанарын ялгааг бууруулна.

4.1 Алтанбулаг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

4.2 Сумын хэмжээний бохир ус татан зайлуулах шугамын зураг төсвийг боловсруулж, гэр хорооллын айлуудыг бохирын шугамд холбох ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлж ажиллана.

4.3 “Хашаандаа сайхан амьдарцгаая” хөтөлбөр хэрэгжүүлж, Соёлч өрх, шилдэг гудамж уралдааныг жил бүр зохион байгуулж шалгаруулан, туршлагыг түгээн дэлгэрүүлэх сурталчлах ажлыг зохион байгуулна.



4.4 “Манай гудамж – Миний гэр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, айл өрхөөрөө хамтран бүтээлч ажил өрнүүлж, оршин суугаа орчноо тохижуулахад нь туслалцаа үзүүлнэ.

4.5 Залуу гэр бүлд нэг удаа орон сууцтай болоход бодлогоор дэмжиж ажиллана.

4.6 Суурьшлын шинэ бүсэд худаг шинээр гаргаж, цахилгаан эрчим хүчний суудлыг шийдвэрлэнэ.

4.7 Хог хаягдлын нэгдсэн цэгийг хашаажуулан камержуулж хараа хяналттай, эмх цэгцтэй болгоно.

4.8 Залуучуудын хөгжих, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн клуб, холбоод ТББ-дыг дэмжиж ажиллана.

ТАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

5.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж иргэн аж ахуйн нэгжид олгох зээлийг аймаг, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.

5.2 Хоршоо, нөхөрлөлд гишүүнээр элсэн ажиллах хүсэлтэй ажилгүй, зорилтот бүлгийн өрх иргэдийн саналыг үндэслэн зуучлах үйл ажиллагааг зохион байгуулна.

5.3 Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан сургалт зохион байгуулж, төсөл хөтөлбөрт хамрагдах боломжоор хангаж ажиллана.

5.4 Бүтэн өнчин, хараа хяналтгүй хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, ганц бие, ахмад настан, тусгай хэрэгцээт иргэн асаргаа шаардлагатай хэвтрийн өвчтэй иргэнийг асарч байгаа гэр бүлийг төсөл хөтөлбөрт хамруулах талаар санал, санаачилгыг дэмжиж ажиллана.

5.5 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Аж ахуйн нэгж, ТББ-тай идэвхтэй хамтран ажиллана.

Газар тариалан

5.6 Атрын IV аяны хүрээнд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнийн өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн гаргана.

5.7 Ногоочдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, техник технологийн төсөл хэрэгжүүлэгч ОУ-ын байгууллага болон Хөдөө аж ахуйн яамны төсөл хөтөлбөрүүдэд хамруулна.

5.8 Төр төсвийн байгууллагад ажилладаг төмс хүнсний ногоо эрхлэх зорилготой ард иргэдийг дэмжиж ажиллана.



5.9 Сумын иргэдийн санал санаачилгад тулгуурлан өвөл зуны хүлэмж, зоорины аж ахуйг хөгжүүлнэ.

5.10 Төмс хүнсний ногоо нөөшлөх, савлах боловсруулах цехийг худалдааны төвд байршуулан дэмжиж ажиллана.



Мал аж ахуй.

5.11 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх хөтөлбөрийн хүрээнд малын тоо толгойг зохих түвшинд барьж, үйлдвэр угсааг сайжруулж, мал аж ахуйн фермерүүдийг дэмжиж ажиллана.

5.12 Мал бүхий иргэдийн мах сүүг худалдааны төвд төвлөрүүлж, малчдын орлогыг нэмэгдүүлэн, сүү боловсруулах цехийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дэмжиж ажиллана.

5.13 Мал эмнэлгийн үйлчилгээ, чанар хүртээмжид онцгой анхаарч "Эрүүл мал-Эко хүнс" зорилт тавьж ажиллана.

5.14 Малчин, мал бүхий иргэдийн бэлчээр, хадлан бэлтгэлийн ажлыг технологийн хугацаанд хяналт тавьж, зудын эрсдэлийн нөөц бий болгож ажиллана.

5.15 Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн боловсруулах хоршоо цехийг бодлогоор дэмжиж ажиллана.

5.16 Ногоон тэжээл тариалах аж ахуйн нэгж, малчин иргэдийг дэмжиж ажиллана.

Аялал жуулчлал.


5.17 "Сэлэнгэ аялал жуулчлал" аймгийн хөтөлбөрийг улс орны хөгжлийн шинэ зорилтуудтай уялдуулан олон нийтийн байгууллага, иргэдийн саналд үндэслэн хэрэгжүүлнэ.

5.18 Сайхны хөтлийн аялал жуулчлалын бүтээн байгуулалтыг дэмжиж хамтарч ажиллана.

5.19 Нутгийн иргэдийг оролцуулан тогтвортой эко аялал жуулчлалыг хөгжүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

5.20 Алтанбулаг дотоодын аялал маршрут боловсруулж, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэн орон нутгийн амралт, зуслангуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

Байгал орчин.



5.21 Ойн нөөцтэй орон нутгийн онцлогийг уялдуулж, байгаль орчны багц хуулиудыг мөрдлөг болгон ажиллана.

5.22 Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, зохистой ашиглан хамгаалах нөхөн сэргээх, ажлыг зохион байгуулж хийнэ.

5.23 Байгалийн нөөц ашигласны нөхөн төлбөрийн орлогыг байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд зориулна.

5.24 Мод үржүүлэг, ойжуулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

ЗУРГАА. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1 Алтанбулаг-Хиагтын Засаг захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлнэ.

6.2 Малчид тариаланчдын залгамж халааг бэлтгэх “Илгээлтийн эзэн – 3” аяныг сумынхаа онцлогт тохируулан хэрэгжүүлнэ

6.3 Алтанбулаг брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

6.4 Өрхийн үйлдвэрлэгч, хоршоо, бүлгийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж агро парк байгуулна. /төмс, хүнсний ногоо, зоорь, хүлэмж/

6.5 ХАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүн боловсруулах, мод модон эдлэлийн цех, ойн хаягдал, түүхий эд боловсруулах цех, модны үрсэлгээ, суулгацын аж ахуй, техник тоног төхөөрөмжийн үйлчилгээний цех, мал бордох газар зэрэг ХАА, хөнгөн үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдэд дэмжлэг үзүүлнэ.

6.6 Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, мал эмнэлгийн чадавхыг дээшлүүлж “Эрүүл малтай” сум болно.

ДОЛОО. СУМЫН ХЭМЖЭЭНД ХИЙГДЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХУРААНГУЙ

- Ирэх жилд Сэлэнгэ нутгийн хөгжил дэвшлийн шаардлагад нийцсэн, МАН-ын 2020 оны сонгуулийн хөтөлбөрт тусгагдсан дараах бүтээн байгуулалтын ажлууд хийгдэнэ. Үүнд:

7.1 Алтанбулаг сумыг “Сумын хөгжил” хөтөлбөрт хамруулж, жишиг сум болгоно.

7.2 Дулааны станц шинээр барих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

7.3 Бохир ус татан зайлуулах ерөнхий шугам тавих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

7.4 Гэр хорооллын сайжруулсан замыг хатуу хучилттай болгож, сэргээн засварлах ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

7.5 Хөдөөгийн нутаг дэвсгэрт байрлах гүүрнүүдийг сэргээн засварлана.

7.6 Соёл мэдээллийн төвийг шинээр барих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

7.7 Суманд 25 ортой эмнэлэг шинээр тавих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

7.8 Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулж түүх соёлын дурсгалт хуучин байшин барилгуудыг сэргээн засварлана.

7.9 Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулж Алтанбулаг суман дахь Ардын хувьсгалын музейг засах ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

7.10 Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулж Сэлэмт хөшөөг цогцолбор болгоно.

7.11 Сумын Нутгийн удирдлагын ордныг дулаан цэвэр, бохирын шугамд холбож, гадна өнгө үзэмжийг сайжруулна.

7.12 Хуучин түр засгийн газрын байрыг сэргээн засварлаж “Ёслол хүндэтгэлийн өргөө” болон орон нутгийн судлах танхим болгон ашиглана.

7.13 Сумын төвийн гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, сайжруулна.

7.14 Нутгийн удирдлагын ордны өмнө талбай байгуулж, авто машины зогсоол шинээр бий болгоно.

7.15 Хөдөөгийн багийн байрыг засварлана.

7.16 Шарил хадгалах байрыг шинээр барина.

НАЙМ. ШУДАРГА ЁСНЫ ЗАСАГЛАЛ



7.11 Сумын Нутгийн удирдлагын ордныг дулаан цэвэр, бохирын шугамд холбож, гадна өнгө үзэмжийг сайжруулна.

7.12 Хуучин түр засгийн газрын байрыг сэргээн засварлаж “Ёслол хүндэтгэлийн өргөө” болон орон нутгийн судлах танхим болгон ашиглана.

7.13 Сумын төвийн гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, сайжруулна.

7.14 Нутгийн удирдлагын ордны өмнө талбай байгуулж, авто машины зогсоол шинээр бий болгоно.

7.15 Хөдөөгийн багийн байрыг засварлана.

7.16 Шарил хадгалах байрыг шинээр барина.

НАЙМ. ШУДАРГА ЁСНЫ ЗАСАГЛАЛ

Төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай байдлыг нэмэгдүүлж, чирэгдэл, доголдол, хүнд сурталгүй үйлчилгээний стандартыг хэрэгжүүлж, төсвийг ил тод, олон нийтийн хяналтын доор зарцуулж тайлагнах нөхцөлийг бүрдүүлнэ.

8.1 Төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, гүйцэтгэлийг иргэдэд ил тод мэдээлж байна.

8.2 Төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалтын тендерийн сонгон шалгаруулалт болон гүйцэтгэлийн үе шаттай хяналтыг иргэдийн оролцоотойгоор шударгаар дүгнэж иргэдэд тайлагнана.

8.3 Орон нутгийн төсөв болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг иргэдийн оролцоотой төлөвлөн тэдний амин чухал хэрэгцээг хангахад зориулан зарцуулж, хяналтыг сайжруулна.

8.4 Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нийгмийг соён гэгээрүүлэхэд хамтран ажиллана.

8.5 Төсөв санхүүгийн сахилга хариуцлагыг чангатгаж, төсвийн хөрөнгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оновчтой, үр ашигтай зарцуулахад иргэд, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлнэ.

Алтанбулаг сумын Монгол Ардын намын хороо

